

ХОВД ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН “ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ” ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2015.12.11

д/д	Хэрэгжүүлэх ажил	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Гүйцэтгэл
1	БОЭТ-ийн албадуудын дарга болон тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарыг менежментийн сургалтанд хамруулах	Удирдлагын түвшинд чадавхжуулах сургалтыг холбогдох газраас сургагч багшийг урьж сургалт хийх	Удирдах ажилтнуудын менежмент \төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт үр дүнгээ тооцох \-ийн үйл ажиллагаа сайжирна.	<p>Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Гүйцэтгэлийн хяналт шинжилгээ үнэлгээ”-ний 5 өдрийн сургалтанд БОЭТ-ийн захирал Т.Баяртогтох хамрагдаж ирээд Удирдлагын багийн гишүүдэд дотоод сургалтыг зохион байгуулсан. Удирдлагын багийн гишүүдээс 2015 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Чанарын албаны дарга, менежер, сувилахуйн албаны дарга нарыг “Эрүүл мэндийн салбарын удирдлага, мэдээ тайлагналт, хяналт үнэлгээ хийх арга зүй, албан бичиг хэргийн хөтлөлт” зэрэг сэдвүүдээр сургалтанд хамруулсан. Мөн хяналт үнэлгээ хийх аргачлал, төсөл боловсруулах тухай сургалтыг холбогдох мэргэжилтнүүд болон дотоодын сургалтын хуваарийн дагуу хийгдэж байна.</p> <p>Клиникийн 3-р эмнэлгийн сувилахуйн албаны дарга Ш.Цэрмааг урьж “Сувилахуйн стратегийн хэрэгжилт” сэдвээр сургалт зохион байгуулж БОЭТ-ийн 22 тасгийн ахлах сувилагч нар хамрагдлаа. Мөн Ш.Цэрмаагаас ажлын байрны арга зүйн зөвлөгөө авч харилцан туршлага судлав.</p> <p>Эмнэлгийн дунд шатны удирдлагын мэдлэг ур чадварыг сайжруулах зорилгоор “Удирдах ажилтны ур чадварыг хөгжүүлэх нь” сэдэвт сургалтыг 2015.10.07-08 ний өдрүүдэд амжилтай зохион байгуулж сургалтын сургагч багшаар ЭМХҮТ-ийн Байгууллагын хөгжил, стратеги төлөвлөлт эрхэлсэн мэргэжилтэн Н. Нарангэрэл ажиллаж сургалтанд БОЭТ- тасгийн эрхлэгч, менежер сувилагч болон дунд шатны удирдлагууд оролцлоо.</p> <p>БОЭТ-ийн захирал Т.Баяртогтох Улаанбаатар хот болон Филиппин улсад эмнэлгийн удирдлага чиглэлээр туршлага судлах сургалт аялалд хамрагдсан. Захирлын зөвлөлийн гишүүн, Сувилахуйн албаны дарга М.Бадамцэцэг болон 1 арга зүйч, 4 ахлах сувилагч нийт 6 хүн Улаанбаатар хотод “Сувилахуйн удирдлага манлайлын” сургалтанд хамрагдаж Улсын II-р төв эмнэлэг, Ганд-мед эмнэлэгүүдээр туршлага судлаж сайн туршлагыг байгууллагад нэвтрүүлэн төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p> <p>Захирлын зөвлөлийн гишүүн ҮЭХ-ны дарга, мэс заслын их эмч Б.Сүхнаран Удирдлагын академийн Төрийн удирдлагын менежерийн ангид элсэн удирдахуйн ухаанд суралцаж байна.</p> <p>Захирлын зөвлөлийн гишүүн, Ерөнхий нягтлан бодогч Д.Баярсүрэн мэргэшсэн нягтлан бодогчдийн институтаас зохион байгуулсан Ахисан шатны түвшин олгох кредитын сургалт болон Улаанбаатар хот, замын үүдэд туршлага судлах сургалт аялалд хамрагдсан.</p> <p>Тайвань улсад удирдахуйн ухаанаар магистрийн зэрэг хамгаалсан Б.Алтанчимэг нь БОЭТ-ийн сургалт эрдэм шинжилгээний гадаад харилцааны албаны дарга, Захирлын зөвлөлд ажиллаж байна.</p>

2	<p>БОЭТ-ийн захирал албадын дарга болон тасгийн эрхлэгч нартай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж гэрээний биелэлтийг улирал тутам тооцож хяналт тавьж ажиллах</p>	<p>Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар баталсан журмын дагуу БОЭТ-ийн захирал бүх тасгийн эрхлэгч нартай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулсан байна.</p>	<p>Үр дүнгийн гэрээний биелэлтийг улирлаар дүгнэснээр ажлын хариуцлага хөдөлмөрийн бүтээмжид үнэлгээ өгч зохих арга хэмжээг авч ажиллана.</p>	<p>БОЭТ-ийн тасаг нэгжийн 22 эрхлэгч, менежер нартай үр дүнгийн гэрээ байгуулж гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр тооцож ажиллаа. Үр дүнгийн гэрээг тасаг нэгжийн ахлагч нартай байгуулан дүгнэж ажилласнаар:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тасгийн эрхлэгч эмч менежер нарын албан бичиг хэрэг хөтлөлтийн чадвар, хариуцлага хүлээн ажиллах байдал сайжирсан. 2. Үр дүнгийн гэрээний хагас жилийн биелэлтийн тайланг үндэслэн тасаг нэгжүүдийн үндсэн үйл ажиллагааны болон тоон үзүүлэлтэнд 2 удаа үнэлэлт дүгнэлт өгч, сайжруулан ажиллах талаар зөвлөмж хүргэгдсэн. 3. Тасаг нэгж бүр дээр үндсэн үйл ажиллагааны хэрэгжилтийн байдал, тулгамдаж байгаа асуудал сайжруулах арга зам, нөөц ашиглалт, эерэг харилцаа хандлага, багаар ажиллах талаар удирдлагын багийн гишүүд оролцож өргөтгөсөн ярилцлага хийж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргасан. Үүний дүнд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад тасаг нэгжийн хамт олны үйл ажиллагааг нэгтгэх, эмч ажилчдын ажлын цаг ашиглалт, эерэг хандлага хариуцлага сайжруулах зөвлөмж гарсан. Зөвлөмжийн дагуу Амаржих газарт өртөмтгийн эхчүүдийг хянадаг 2 кабинет ажиллуулах, хүлээн авах яаралтай тусламжийн тасгуудын үйлчлэгчийг 4 ээлж болгох, шүд, эхо, дотор, шинжилгээний тасгуудыг 2 ээлжээр ажиллуулах, амбулаторийн үзлэг хийдэг эмч нарыг хөрвүүлж ажиллуулах зэрэг ажлуудыг шийдвэрлэж ажилласан. <p>Үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлангийн үнэлгээгээр тасаг нэгжийн менежерүүдийн 15,8 хувь маш сайн, 42,1 хувь нь сайн болон хангалттай гэсэн үнэлгээгээр тус тус үнэлэгдсэн байна. Гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн хэрэгжүүлэх ажлын санал дээр байгууллагын орон байр, өрөө тасалгааны хүртээмжийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах санал зонхилон гарсныг төлөвлөгөөтэйгээр шийдвэрлэн ажиллаж байна.</p>
3	<p>Тусламж үйлчилгээний чанарын өдөрлөгийг амаржих газрын амбулаторийн тасаг, БОЭТ-ийн амбулаторийн тасгуудад хийж үр дүнг тооцох</p>	<p>Чанарын өдөрлөг хийх төлөвлөгөө боловсруулж төлөвлөгөөний дагуу зохион</p>	<p>Чанарын хөтөлбөр боловсруулан төлөвлөгөөг гарган үр дүнг тооцсон байна.</p>	<p>Тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй, үе шаттайгаар сайжруулах ажлыг тогтмол хийж үр дүнг тооцон ажиллаж байна. 2015 оны 06 дугаар сарын 30,31-ний өдрүүдэд Сэтгэл нийцсэн зөвлөгөө сэдэвт өдөрлөгийг БОЭТ-ийн нийт тасгуудын дунд чанарын албанаас зохион 50 эмч нар, 60 үйлчилгээний ажилчид, 358 үйлчлүүлэгч оролцон зохион байгууллаа. Өдөрлөгийг иргэдийн дунд гадна талбайд зохион байгуулсан ба нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөө өгөх 12 өртөө үүсгэн 45 эмч мэргэжилтэн ажиллаж, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл өгч, гарын авлага, санамж, эрүүл мэндээллийн хуудсууд тараасан. Өдөрлөгийг орон нутгийн телевиз, сонин хэвлэлээр суртчиж, иргэдээс асуумж судалгаа авч ажилласан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдэд зөвлөн туслах, зөв харилцаа хандлагыг төлөвшүүлэх зорилгоор дэмжих үйлчилгээний 60 ажилтанд стрессийн тухай ойлголт, стресс тайлах аргууд сэдвээр Сэтгэц наркологиын тасгийн их эмч С.Цэрмаа, Эмнэлгийн ажилтний</p>

		байгуулж үр дүнг тооцон ажилласан байна.		<p>харилцаа хандлага сэдвээр Чанарын албаны дарга Ч.Нямаахүү нар сургалт явуулж сургалтын дараа АХА тэмцээн явуулсан нь үр дүнтэй боллоо.</p> <p>Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор 50 эмч мэргэжилтэнд Байгууллагын соёл, үйлчилгээний соёл, эрүүл мэндийн үйлчилгээний онцлог сэдвээр Хүний гавьяат эмч Ж.Даваабал, ЭМСайдын 2012 оны 334 дүгээр тушаалын дагуу Сэтгэлд нийцсэн найман үйлчилгээний удирдамжаар Чанарын албаны дарга Ч.Нямаахүү, Дэлхийн алдартай эмнэлгүүдийн жишээ, видео кино Сургалтын албаны дарга Б.Алтанчимэг, харилцааны урлаг хандлагад суралцах нь сэдвээр Ч.Нямаахүү нар сургалт явуулж бүлгээр ажиллуулах өөрийн хандлагаа үнэлэх сорилоор оролцогчдын хандлагыг үнэлэх, харилцах ярилцах зэрэг аргуудыг ашиглан сургалт явуулж өдөрлөг зохион байгуулсан.</p> <p>Дээрх өдөрлөг сургалт бусад арга хэмжээний хүрээнд эмч мэргэжилтэн ажилчид болон иргэдээс тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдийн хүлээгдэл чирэгдлийг багасгах, тусламжийн хэрэгцээт нэр төрлийн талаар судалгаа авч, хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласнаар цахим бүртгэлээс дугаар авах тогтолцоог хяналттай болгох, амбулаторийн үзлэгийн ачаалал ихтэй тасаг нэгжүүдийн хүний нөөц бусад зардлыг шийдвэрлэн 2 ээлжээр ажиллуулах, үйлчлүүлэгч шинжилгээний хариу болон үзлэгт цаг товлох үйлчилгээг цахим аргаар авах боломж бүрдүүлж, амаржих газрын эмч мэргэжилтний ажлын ачааллыг тэнцвэржүүлж, өртөмтгийн эхчүүдийг хянадаг кабинетийг нэмэгдүүлж ажилласнаар иргэдээс авдаг сэтгэл ханамжийн судалгааны дүн сайжирч, амбулаторийн хүлээгдлийн хугацаа буурч, эх хүүхдийн тусламж үйлчилгээ сайжирсан.</p>
4	Хорт хавдрын бүртгэл, мэдээлэл, эргэн дуудах тогтолцоог боловсронгуй болгож, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах Хүний нөөцийг чадавхжуулах, Олон нийтэд хавдраас урьдчилан сэргийлэх үзлэг болон сургалт сурталчилгааг зохион байгуулах.			<p>Зорилтот бүлгийн иргэдийн хавдрын эрт илрүүлгийн болон урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах тогтолцоог сайжруулах, мэдээллийн тогтолцооны нэгдмэл байдлыг хангах, эргэн дуудах товллол тогтолцоог үр дүнтэй болгох зорилгоор ЭМГ-тай хамтран сум, өрхийн эмч, дүн бүртгэлийн бага эмч нарын сургалт, уулзалтыг 2015 оны 02 дугаар сарын 11-13 нд хийсэн. Сургалтын үеэр хавдрын илрүүлэлт, бүртгэл хяналт, эргэн дуудах тогтолцоог сайн хэвшүүлсэн. Эрдэнэбүрэн, Мөнххайрхан сумын ЭМТ-ийн эмч нарын туршлагыг түгээн солилцсон. Мөн аймгийн хэмжээнд тэргүүлэх шалгаант хавдруудыг эрт илрүүлэх хяналтанд авах тогтолцоо бүрдүүлж, сум өрхийн ЭМТ-үүдийн хэт авианы оношилгооны аппарат, элэгний В, С вирусын оношлуураар хангах саналыг аймгийн ЭМГ-г хрүүргүүлсэн. Мөн хавдрын өвчлөлийг эрт илрүүлэх хяналтын чанарыг сайжруулах зорилгоор “Хавдрын эсрэг үндэсний аян”г ХСҮТ, МҮОНРТ, Хаан банк-тай хамтран 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулсан. Үүнд: ХСҮТ-өөс</p> <ol style="list-style-type: none"> 1. Эмэгтэйчүүдийн эмч 2. Толгой, хүзүү мэс заслын эмч 3. Ерөнхий хавдарын эмч 4. Эс судлаач эмч 5. Ходоодны дурангийн эмч

				<p>6. Эмэгтэйчүүдийн ЭХО, шинжилгээний эмч ажиллаж 1701 хүнд үзлэг шинжилгээ хийж, 13 хавдрын тохиолдол илрүүлсэн.</p> <p>“Хавдрын эсрэг үндэсний аян -2015” –ын хүрээнд Хавдар судлалын эмч нар Сайн дурын гишүүдэд 2015.06.16-ны10 цагт сургалтанд -32 хүн, Эмч нарын 2015.06.16-ны 14-16 цагт сургалтанд- 54 хүн хамрагдлаа. Хавдрын тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч мэргэжилтнийг чадавхижуулах богино хугацааны 2 удаагийн сургалтанд 67 их эмчийг хамруулж, хавдрын эрт илрүүлгийн оношилгоо шилжүүлэлт, хөнгөвчлөх эмчилгээний талаар сургалтыг хийсэн.</p> <p>БОЭТ нь 2015 онд Төрийн санхүүжилтээр ХСҮТ-д их эмч Г.Энхцэцэгийг хавдар судлаач эмчээр сургаж байна. одоогоор Хөнгөвчлөх эмчилгээний эмч-1, хавдар бүртгэгч-1, хими эмчилгээний эмч-1, хөнгөвчлөх эмчилгээний сувилагч-1 тус тус ажиллаж байна. Хөнгөвчлөх тусламж үзүүлдэг 2 өрөөнд 4 орыг тогтмол ажиллуулж байна. Хавдар судлалын үндэсний төвөөс зохион явуулсан “Хөх умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэлтийн хөтөлбөрийг эрчимжүүлье” аяны хүрээнд БОЭТ дараах ажлуудыг төвөвлөн хийж гүйцэтгэлээ. 2015 оны 11 сарын 12-ны өдөр БОЭТ-ийн амбулаториор үйлчлүүлж буй 80 гаруй үйлчлүүлэгчдэд хүн амын дундах хорт хавдраас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгч, сургалт хийж, 500 ш гарын авлага, сургалтын материал тараалаа. Хавдар судлалын кабинетын их эмч Д. Атарбат нь ард иргэдэд зориулсан хорт хавдар түүнд нөлөөлөх хүчин зүйлийн талаар Facebook group ажиллуулж зөвлөгөө мэдээлэлээр ханган ажиллаж байна.</p> <p>Мөн хавдар судлалын үндэсний төвөөс зохион явуулсан телемедицины зайн сургалтанд хавдрын эмч, сувилагч, амаржих газрын 2 бага эмч, ЭМГ-ын мэргэжилтэн нар дараах сэдвүүдээр хамрагдаж мэдлэг мэргэжлээ дээшлүүллээ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөнгөвчлөх тумламж үйлчилгээний хууль, эрх зүйн орчин 2. Хорт хавдартай өвчтөнд үзүүлэх сэтгэл зүйн тусламж 3. Хорт хавдартай өвчтний хоол, гэжээл 4. Хөх, умайн хүзүү, элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн бүртгэл, тандалтын талаар 5. Хорт хавдрын үеийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ 6. Хорт хавдартай өвчтөнд үзүүлэх нийгмийн тусламж үйлчилгээ <p>2015 онд</p> <ul style="list-style-type: none"> • Нийт үзлэг: 3219 үүнээс <ul style="list-style-type: none"> ◦ Урьдчилан сэргийлэх 1701 • Шинээр илэрсэн хавдар 145 <ul style="list-style-type: none"> - Эрт үедээ буюу 1,2 дугаар шатандаа 35 хүн 24,1% • Одоо хяналтанд хянагдаж байгаа 388 <ul style="list-style-type: none"> - Анх оношлогдсоноос хойш 5 дээш жил амьдарч байгаа 162 буюу 42%-ийг эзэлж байна
--	--	--	--	--

	<p>БОЭТ-д үзүүлж байгаа зарим тусламж үйлчилгээний бодит зардлыг нэгдсэн аргачлалын дагуу тооцон дараа оны төсвийн төсөөлөлд тусгах</p>	<p>Бодит өртгийн тооцоо гаргасан тусламж үйлчилгээний төрөл, тоо</p>	<p>Байгууллагын төсвийн төлөвлөлтийг бодитойгоор тооцон эрх барих байгууллагад уламжлан шийдвэрлүүлснээр санхүүжилт нэмэгдэн тусламж үйлчилгээний чанар сайжирна.</p>	<p>Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв 2016 оны төсвийн төсөөлөл нь 2015 оны 07 сарын 17-нд Аймгийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн ба ЭМСЯаманд 2015 оны 07 сарын 27-нд хянуулсан. 2015 онд нийт 5668,3 төгрөгний төсөвтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан.</p> <p>Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь Ховд аймгийн болон Баруун бүсийн таван аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байна. 2015 онд нийт санхүүжилтийн 74%-ийг Эрүүл мэндийн даатгалаас авахаар төсөв батлагдаж ирсэн ба санхүүжилтийг бүрэн гүйцэт авч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахын тулд 2 дахин их ачаалалтай ажилласан</p> <p>2015 онд стационароор 12777 хүн хэвтэн эмчлүүлж орны фонд ашиглалт 119,6%, Амбулаторийн нийт үзлэг 119191 хүрч ачаалалтай ажилсанаар эмийн зардал нь батлагдсан төсвөөс хэтэрч эмийн өглөг 108,4 саяд хүрсэн боловч агуулахын үлдэгдэл 58 сая төгрөг байна. Даатгалаас авах санхүүжилтийн төлөвлөгөө биелүүлэхтэй холбоотой эмийн өглөгөөс гадна байгууллагын хэмжээнд бараа үйлчилгээний бусад зардалууд өсөж өглөг үүсгэж байна. Мөн 2015 онд шинэ дулаантай холбогдсон, цэвэр бохир усны гэрээ шинэчлэгдсэн. Эдгээр зардалууд болон бусад зардалыг тус бүрээр нь төсөвлөж 2016 оны төсвийн төсөөллөлөө 7583,5 сая төгрөг байхаар 2015 оны 07 дугаар ард ЭМСЯ-нд хянуулсан боловч 2015.12.07-нд 2016 оны төсөв 6273,4 сая төгрөгөөр батлагдаж ирсэн нь өмнөх оныхоос 605,1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.</p>
5	<p>НЭМ-ийн хөтөлбөр тус бүрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу тайланг хагас бүтэн жилээр гаргаж шалгуур үзүүлэлтэнд үнэлгээ өгөх, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хавтасжуулан баяжуулалт хийх НЭМ-ийн хөтөлбөр, стратегүүдийн хэрэгжилтийг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэхэд шинэ санаа, дэвшилтэт аргыг нэвтрүүлж, зарим хөтөлбөрийг орон нутгийн онцлогтой уялдуулан загвар хэлбэрээр хэрэгжүүлж,</p>			<p>Хүн амын эрүүл мэндийг хамгаалах дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалт суртчилгааны талаарх Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийн товллоор НЭМ-ийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боловсруулан мөрдөж ажиллалаа.</p> <p>2015 оны 01 дүгээр сарыг “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” сар болгон зарлаж ахуйн болон зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх, хүүхдийн эрүүл аюулгүй орчинд өсөх суралцах нөхцлийг хангах, өвлийн улиралд хятад мотоциклийн хөдөлгөөнийг хязгаарлах талаар иргэд олон нийтэд зориулсан сургалт суртчилгаа, мэдээллийг ЭМГ, гэмтлийн тасгийн эмч Д.Цэрэнбадам, С.Коля нартай хамтран орон нутгийн телевизээр /Ховд телевиз, олон ястны телевиз/ товллын дагуу явуулсан. Дулааны улиралд хятад халуун тогооны түлэгдлээс хүүхдийг сэргийлэх талаар эцэг эхчүүдэд зориулсан сэрэмжлүүлгийг тогтмол хүргэсэн. Мөн хүлээн авах яаралтай тусламжийн тасаг дээр “Түлэгдлийн үед үзүүлэх яаралтай тусламжийн багц”-ийг байршуулан ашиглаж байна. Түлэгдлийн үед үзүүлэх тусламжийн чанар сайжирснаар түлэнхий өвчний үеийн хүндрэл буурсан, нас баралт гараагүй болно.</p> <p>Ажлын байрны осол гэмтлээс сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор “Аюулгүй байдлыг хангая-Анхаарал болгоомжийг нэмэгдүүлье”</p>

<p>үр дүнг тооцож ажиллах</p> <p>Зорилтот бүлгийн хүн амын \нөхөн үржихүйн насны, өсвөр үе, эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны \эрэлт хэрэгцээнд тулгуурласан эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.</p> <p>Осол гэмтэл, түлэгдэл, хордлогоос сэргийлэх сэрэмжлүүлэг, зөв зан үйлийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах</p> <p>Өглөөний алхалт, идэвхтэй хөдөлгөөн, зохистой хооллолт, эрүүл мэндийн хяналт зэрэг аянг зохион байгуулах</p>		<p>уриан дор өрнүүлсэн 3 сарын аяны хүрээнд иргэд, эмч ажилчдын дунд нээлт хийж, аяны хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөг танилцуулан хэрэгжүүлж ажиллалаа. Аяны үеэр ажил байрны эрсдлийн үнэлгээг тасаг нэгж бүр ижил мэргэжилтний уулзалт үнэлгээ хэлбэрээр зохион байгуулж, эмч ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг зохион байгуулж, эрүүлжүүлэх төлөвлөгөө гаргаж, ажлын байранд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлийг бууруулах зөвлөмж тасаг нэгжүүдэд хүргэж ажилласан.</p> <p>2015 оны 02 дугаар сараас Хүн амын эрүүл мэндийг дэмжих, халдварт бус өвчлөлөөс сэргийлэх эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, зорилтот бүлгийн иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөгөө гаргаж мөрдөж ажилласнаар 2015 онд 76 байгууллагын 978 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан эрүүл мэндийн бүлгийг тогтоон анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нарийн мэргэжлийн эмчтэй хамтран хянах санал хүргүүлэн ажиллаж байна. Мөн үзлэг шинжилгээнд хамрагдсан албан байгууллагын эмч, хүний нөөц болон ХАБ-ын ажилтнуудад байгууллагын ажилтнуудын эрүүл мэндийн байдал, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөв зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжигч ажлын байр, эрүүл хамт олон болох зөвлөмжийг 16 удаа өгч ажилласан. Хөдөөгийн малчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах өвчлөлийг эрт илрүүлэх хүндрэлээс сэргийлэх зорилгоор давхардсан тоогоор 25 удаагийн үзлэг сум, багаар хийж 13000 гаруй хүнийг хамруулсан.</p> <p>Сүрьеэтэй тэмцэх өдрийг угтан ажлын төлөвлөгөө гаргаж мөрдөж ажилласнаар Жаргалант сумын Наран баг, Булган сумын 1000 хүнд сүрьеэ өвчнийг илрүүлэх тандалт үзлэг шинжилгээг хийж, сорьц цуглуулах шинжилгээг үнэ төлбөргүй, иргэдэд сургалт сурталчилгаа хийсэн. Энэ үеэр халдвартай хэлбэрийн 2 тохиолдол илэрч эмчилгээнд хамруулсан. Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт эрүүл мэндийн байгууллагад хандах талаар гарны авлага боловсруулан тараасан. Мөн иргэдэд зориулсан сургалт мэдээллийг эмч Б.Оюунцэцэг Ховд телевтээр 24 удаа, орон нутгийн FM 8 удаа нэвтрүүлэг хийсэн. БОЭТ-ийн эмч мэргэжилтнүүдэд “Сүрьеэ өвчний оношилгоо эмчилгээний орчин үеийн чин хандлага, хяналттай эмчилээний онцлог” сургалтыг 3 удаа, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд “сорьц тээвэрлэлт, хадгалалт, халдвар хамгаалал” сумдын эмч нарт БЦЖ вакцин болон туберкулины сорил тавих сургалтуудыг тус тус хийсэн.</p> <p>Олон улсын гэр бүлийн өдрийг тэмдэглэх хүрээнд сар бүрийн 2 дахь ням гаригийг Ховд аймгийн хэмжээнд “Гэр бүлийн өдөр” болгосонтой холбогдуулан гэр бүлийн үзлэг, зөвлөгөө өгөх, эрүүл мэндийг дэмжих, хорт зуршил эрсдэлт хүчин зүйлээс ангид байх, эрүүл мэндийг дэмжигч гэр бүл болох болзлыг суртчилах зэрэг олон нийэд чиглэсэн арга хэмжээг мэргэжлийн эмч нар товлолоор явуулж байна.</p> <p>Дархлаажуулалтын өдрүүдийг төлөвлөгөөний дагуу дархлаажуулатын талаар эцэг эхэд зөвлөгөө өгөх, товлот хугацаанд дархлаажуулалтанд хамрагдахын ач тус, тарилгат халдварт өвчлөл үэрэг сэдвүүдээр иргэдэд мэдээлэл өгсөн. Мөн дархлаажуулалтын урвал хүндрэл,</p>
---	--	---

			<p>аюулгүй тарилга хийх нөхцөл бүрдүүлэлт зэрэг сэдвийн хүрээнд эмч мэргэжилтний ярилцлага хийсэн.</p> <p>Сэтгэцийн эрүүл мэндийн өдрийн угтсан сарын аянг эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудтай хамтран зохион байгуулж тайланг нэгтгэж хүргүүлсэн.</p> <p>БОЭТ-ийн эмч нарын хариуцан хэрэгжүүлдэг НЭМ-ийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, биелэлтийг дүгнэхэд Халдварт өвчинтэй тэмцэх хөтөлбөр, НҮЭМ-ийн хөтөлбөр, Тэгш дүүрэн хөтөлбөр, сэтгэцийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, Осол гэмтлээс сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт сайн байна. Харин Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчинтэй тэмцэх хөтөлбөр, хорт хавдартай тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт шийдвэрлэгдээгүй, салбар хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй, хүн амын эрүүл мэндийн боловсрол сайнгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.</p>
6	<p>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бүс нутгийн хүн амд хүргэхэд чиглүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх, бүс нутгийн хүн амын эрэлт хэрэгцээ, нотолгоонд суурилсан үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх</p>	<p>Бүс нутгийн иргэдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.</p>	<p>1.Бүсийн харьяа аймгуудын алслагдсан сум багийн иргэдэд үндсэн нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгийг хүсэлтийн дагуу зохион байгуулж байна. 2015 онд Завхан аймгийн Өмнөговь, Дөрвөлжин сумын 32 иргэн, Говь-Алтай аймгийн Дарви, Хөхморьт сумын 26 иргэн, Увс аймгийн Цагаанхайрхан сумын 14 иргэн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан. Мөн дуран, нүдний кабинет, сэхээн, мэдрэл, төрөх тасгаар үйлчлүүлсэн иргэдийн тоо урд оныхоос нэмэгдсэн байна. Бөөр орлуулах эмчилгээнд 11 хүн харьяа аймгуудаас хамрагдаж эмчлүүлж байна.</p> <p>2. Баруун бүсийн хүн амын Чихрийн шижин хэв шинж 2 өвчний үеийн хүндрэлийн тархалт, нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа нэг сэдэвт эрдэм шинжилгээний судалгаа хийгдэж доторын эмч Д.Отгонбаяр Анагаах ухааны доктор цолыг амжилттай хамгааллаа. Мөн Баруун бүсийн перинаталь эндэгдлийн судалгаа судалгааг нярайн эмч Ц.Солонго хийх шатандаа явагдаж байна. Баруун бүсийн аймгуудын хүүхдүүдийн дундах сул харааны эмгэгийн тархалт, Баруун бүсийн хүн амын давсны хэрэглээний судалгаа, Баруун бүсийн хүн амын сэтгэцийн байдлын судалгаа, Баруун бүсийн хүн амын тархины цус харвалтанд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа, баруун бүсийн аймгуудын элэгний вирусын шалтгаань архаг үрэвслийн эмчилгээний үр дүн зэрэг судалгааны ажлуудын БОЭТ-ийн эмч нар ахлан бүс нутгийн хэмжээнд хийж байна.</p>
7	<p>Харьяалах бүс нутгийн аймгуудын нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах, мэргэжил арга зүйгээр тогтмол хангах, эргэх холбоотой ажиллах</p>	<p>Эмч мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар сайжирна.</p>	<p>1.Харьяа аймгуудын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах санал хүргүүлсэн. Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилээний эмч мэргэжилтнүүдэд Бөөрний орлуулах диализын аппаратын хэвийн ажиллагааны горим, засвар үйлчилгээ, диализд өвчтөн оруулах зааварчилгааны талаар ажлын байрны сургалтыг 3 хоног хийж аргачлалаар хангасан. Увс Завхан, Говь-Алтай аймгуудын нэгдсэн эмнэлгийн хүүхэд эх барихын эмч нартай Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн А.Энх-Амгалан, зөвлөх</p>

			<p>Бүсийн нутгийн оюутнуудад хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжрах</p>	<p>эмч Д.Бямбаа, Эх барихын зөвлөх эмч хүний гавьяат эмч Ж.Даваабал нар багш шавийн холбоо тогтоон мэргэжлийн зөвлөгөө тогтмол өгч ажилладаг.</p> <p>2. Ховд аймгийн Эрүүл мэндийн байгууллага үүсч хөгжсөнөөс хойш 90 жилийн түүхэн ойтой холбогдуулан Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, аймгийн Эрүүл мэндийн газар, Бүсийн Оношилгоо Эмчилгээний төв болон тус аймгаас төрсөн анагаах ухааны эрдэмтэн судлаачидтай хамтран Олон Улсын Эрдэм Шинжилгээний бага хурал 2015оны 08-р сарын 13-ны өдөр Нутгийн удирдлагын ордонд амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү хуралд АНУд байрлалтай Virtue foundation олон улсын нүдний эмч нарын нийгэмлэг, БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны төлөөлөгч эмч н. Даваа, Норвегийн тусламжийн байгууллагын төлөөлөгчид болон харьяа аймгуудын нэгдсэн эмнэлэгүүдийн дарга, эмч төлөөлөгч нар оролцож нийт 28 илтгэл хэлэлцүүлсэн. Үүнд Увс аймгаас 1, Говь-Алтай аймгаас 5, Завхан аймгаас 4 илтгэл тус тус хэлэлцүүлсэн байна.</p> <p>3.Харьяа аймгуудын нэгдсэн эмнэлгүүдэд шаардлагатай мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, эргэх холбоо тогтоон үр дүнг тооцож ажиллах Баян-Өлгий аймагт 3, Завхан аймагт 2, Увс аймагт 1 удаа алсын дуудлаганд нарийн мэргэжлийн эмч үйлчилсэн. Бүсийн аймгуудад шүүхийн байгууллагын хүсэлтээр 21 тохиолдолд сэтгэцийн эрүүл мэндийн байдлын дүгнэлт гаргасан. Бүсийн аймгуудын нэгдсэн эмнэлэг, сумдын эмч нартай холбоо тогтоож, хүнд өвчтөн эргэлзээтэй тохиолдлын талаар утсаар болон цахим шуудангаар мэдээлэл солилцож, зөвлөгөө өгч ажиллаж байна.</p> <p>Баян-Өлгий аймагт Нэгдсэн эмнэлгийн захиалга хүсэлтээр Нярайн эмч Ц.Доржхандыг 1 сарын хугацаатай томилон перинаталь эндэгдлийг бууруулах, эрт нярайн нэн шаардлагатай тусламжийг хэрэгжүүлэхэд туслан ажилласан.</p> <p>Баруун бүсийн аймгуудын оюутнууд суралцаж буй ХоИС, Политехник коллежийн оюутнуудад эрүүл мэндийн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тусламжийн чанарыг сайжруулах зорилгоор сургуулийн эмч нартай хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажилласан. Үүнд: Оюутнуудыг амраад ирэх үед эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулах, оюутны байранд жирэмснээс хамгаалах эм, хэрэгсэл бэлэн байлгах, тогтмол үйлчлэх, эрүүл мэндийн боловсрол тусламж үйлчилгээний талаар асуумж судалгаа авах, хорт зуршлаас татгалзах, зөв зан үйлийг дэмжих, стресс тайлах арга зүй, осол гэмтлийн үеийн тусламж зэрэг сургалт хийх, сургуулийн эмчийн захиалгаар цахим үйлчилгээнд бүртгэж, үзлэг шинжилгээнд хамруулах, БЗДХ-ыг эрт илрүүлэх эмчлэн эрүүлжүүлэх, хүүхэдтэй оюутнуудын хүүхдийн идэвхитэй эргэлт , товлот үзлэгийг тогтмол хий зэрэг ажлуудыг хийж байна.</p>
8	Эмнэлэгт хоног болоогүй нас баралт, даралт ихсэх өвчний болон зүрхний	Тохиолдол бүрд судалгаа болон эмгэг бүтцийн,	Нас баралтын түвшинг бууруулж, улс аймгийн дунджийн түвшинд хүргэнэ.	2015 онд БОЭТ-д хоног болоогүй нас баралт 9 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 14,1 %-иар буурсан. Бүртгэгдсэн тохиолдлуудын 3 нь 4 цаг хүртэл хугацаанд, 1 тохиолдол нь 23 цаг 50 минутын ор хоногтой нас баралт байсан. Хоног болоогүй нас баралтын тохиолдол бүрийг эмгэг бүтцийн шинжилгээнд

	<p>шигдээсийн нас баралтын тохиолдолд дүн шинжилгээг хийж бууруулах арга хэмжээ авч ажиллах</p>	<p>клиник конференци хийгдсэн байна. Яаралтай тусламж болон амилуулах тусламжийн сургалтуудад хамруулна.</p>		<p>хамруулах, шалтгааныг судлах, клиник конференци хийх зорилго тавьсан. 2 тохиолдол шүүхийн эмнэлгийн эмгэг бүтцийн шинжилгээнд хамрагдсан. 2 тохиолдол амьд үедээ сорьцоор баталгаажсан хавдрын хүндрэлийн нас баралт тул эмгэг бүтцийн шинжилгээнд ороогүй. Бусад 5 тохиолдлыг эмгэг бүтцийн шинжилгээнд хамруулж, нийт эмч нарын дунд клиник конференци хийхэд 3 нь Артерийн даралт ихэсэлтийн хүндрэлээр тархины цус харвалтын шалтгаант хоног болоогүй нас баралт байгаад дүгнэлт хийж цус харвалтын үеийн тусламж үйлчилгээний багийг байгуулан сургалт хийж, сүүлийн үед эмчилгээнд нэвтэрсэн үр дүнтэй кордапин, цераксон, немотин зэрэг эмүүдийг эмчилгээнд нэвтрүүлж хэвшээд байна. Осол гэмтлийн үеийн анхны тусламжийн чанарыг сайжруулах зорилгоор сургалтыг эмч нарт тогтмолжуулан, түлэнхийн үеийн тусламжийн багцийг хүлээн авах тасагт байршуулан ажиллалаа.</p> <p>БОЭТ-ийн сүүлийн 5 жилийн хоног болоогүй нас баралтанд баримтын судалгаа хийхэд Тархины цус харвалт, Осол гэмтэл, Цусны эргэлтийн дутагдлын шалтгаант эмгэг нас баралт тэргүүлэх шалтгаан болж байна.</p> <p>Цусны даралт ихэсэх өвчтэй өвчтний судалгааг сум, өрх, зүрх судасны эмч нарын түвшинд ангилан гаргаж, цусны даралтаа хянах, эмийн болон эмийн бус эмчилгээг мөрдөх зөв зан үйлд сургах сургалтыг Өрх, сумдын ЭМТ-өө түшиглэн зохион байгуулж, орлого багатай иргэдийг эмийн хөнгөлөлтөнд хамруулж байна. 2015 онд нийт 140 гаруй хүнд эмийн хөнгөлөлт үзүүлсэн байна.</p> <p>Цусны даралт харвах үеийн болон зүрхний шигдээсийн клиник удирдамжийн хэрэгжилтийг сайжруулах, сум өрхийн эмч нарт сургалт зохион байгуулж, гарын авлага удирдамжийг тараасан.</p> <p>Мэдрэлийн их эмч Ц.Гэрэлт-Од “Харвалт өвчнөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр Ховд ТВ нэвтрүүлэгийг 2015 оны 06,07 дугаар сард 2 удаа явуулсаа. Мөн тасаг кабинетээр үйлчлүүлж буй эмчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсролыг үзүүлэх материал самбар ТВ плаш ашиглан өдөр бүр олгож байнга суртачилгаа хийж, гарын авлагыг нийт 800 гаруй эмчлүүлэгчид тарааж, цус харвалттай 70 хүнд өвчтөний ар гэр сахиур 1342 хүнд өдөр тутам ярьж таниулан асаргаа сувилгааны талаар зааж сургасан. Харвалтын дараах саа саажилтай өвчтөний гар хөлийг зөв байрлуулах талаар ар гэр сахиурт нийт 57 хүнд зааж сургасан.Сахиур нь нэг хэлээд сайн тогтоохгүй байгаа тул байрлалыг нь зурагт самбараар хийж эрчимт эмчилгээний өрөөнд хадаж байрлуулсан.</p> <p>АШУҮИС, АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ СУДЛАЛ ТТБ-тай хамтран “Зүрх судас амьсгалын замын менежмент” 1кр-ийн сургалтанд БОЭТ-ийн 58 эмч мэргэжилтэн, өрх сумдын нийт эмч нар оролцсон.</p> <p>ЭМСЯ-ны эмнэлгийн тусламжийн салбар зөвлөлийн дарга Ариунболд, мэргэжилтэн С. Төгсжаргал нар “Амь тэнссэн үеийн яаралтай тусламж” сэдвээр 2015.04.15-18-ны өдрүүдэд БОЭТ-ийн нийт эмч нар, өрх сумдын эмч</p>
--	---	--	--	---

				<p>нарт Мэдрэлийн их эмч Ц.Гэрэлт-Од “Кардив тариаг эмчилгээнд хэрэглэх нь” сэдвээр нийт эмч нарт тус тус сургалт явуулсан.</p> <p>Дээрх сургалтуудыг явуулж эмч мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг сайжруулснаар Цус харвалтын нас баралт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Зүрхний шигдээсийн нас баралт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдол буюу 3,7 хувиар өссөн нь ард иргэдийн эрүүл мэндийн боловсрол дутмаг, эмнэлэгт оройтож хандах хандлагатай холбоотой байгаа тул ард иргэдэд чиглэсэн сургалтуудыг ЭМГ, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтарсан эрүүл мэндийн сургалт сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэрэгслээр хүргэж байна.</p>
9	<p>Байгууллагын цахим хуудсын үйл ажиллагааг тогтмолжуулах, байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн, худалдан авалтын ил тод байдлыг ханган тодорхой ажлуудыг хийж ажиллана. Шилэн дансны хуулийн дагуу цэсийг байршуулж мэдээ мэдээлэлийг сар бүр шинэчлэх, мэдээллийн самбарыг олон нийтэд ил байршуулах</p>	<p>Байгууллагын Цахим хуудсан дээр бүх албад, тасгуудын цаг үеийн мэдээ мэдээлэл байнга тавигдсан байна. Сул чөлөөтэй ажлын байран дээр хүний нөөцийн сонгон шалгаруулалт зохион байгуулна.</p>	<p>Байгууллагын Цахим хуудсаар олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэгдсэн байна. Хүний нөөцийн ил тод байдал хангагдана. Тусламж үйлчилгээний чанар сайжирна.</p>	<p>Байгууллагын ID хаяг emg_boet@yahoo.com, Байгууллагын цахим хуудас www.khovdboet.mohs.mn, facebook хаяг: www.khovdboet.moh/fb гэсэн хаягтайгаар үйл ажиллагаа тогтмол хэвийн явуулж цаг тухайн үеийн үйл явц, мэдээ мэдээллийг олон нийтэд ил тод нийтэлж байна. Байгууллагын вэб хуудсанд шилэн дансны мэдээллийг байршуулсан, бие даасан цэс үүсгэж мэдээллүүдийг бүрэн гүйцэд байршуулсан болно.</p> <p>БОЭТ-ийн захирлын 2014 оны 08 дугаар тушаалын дагуу жил бүр сул болон чөлөөтэй ажлын байр гарсан тохиолдолд ажилчдыг ажлын байранд сонгон шалгаруулалт явуулж холбогдох мэдээллийг цахим болон мэдээллийн самбарт байрлуулсан.</p> <p>Тухайн жилд батлагдсан төсөв, төсвийн зарцуулалт гүйцэтгэл, нэмэлтээр ирж буй санхүүжилт, хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан сар бүрийн мэдээг Шилэн дансны тухай хууль болон Төсвийн тухай хууль бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж санхүүгийн тайлан мэдээг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан ил тод тавьж байгаа. Төсвийн мэдээллийг сангийн яамны нээлттэй нийгмийн хүрээлэн www.khovdtusuv.wordpress.com http://shilendans.gov.mn цахим хуудсаар тогтмол мэдээлж ажилладаг.</p> <ul style="list-style-type: none"> • Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээшхи гүйлгээ мөн санхүүтэй холбоотой бусад мэдээллийг байгууллага дээр байрлах шилэн дансны самбар, http://www.khovdboet.mohs.mn/ дээр сар бүр байршуулдаг.
10	Өр авлагүй ажиллах	Олон талт ажлуудыг зохион байгуулж ажиллана.	Өр авлага буурсан байна.	<p>2015 онд нийт 133,2 сая төгрөгний өр үүссэн байна. Үүнд</p> <p>Халаалтын өр-5,9 сая</p> <p>Цахилгааны өр 16,8 сая төгрөг</p> <p>Сүлжээ интернетийн өр 1,0 сая төгрөг</p> <p>Урсгал засварын өр 1.1 сая төгрөг</p> <p>Эмийн өр 108,4 сая төгрөг</p>

				<p>БОЭТ нь 256 ортой үйл ажиллагаа явуулдаг ба ажиллах хүчин чадлаасаа 1,7 дахин их ачаалалтай ажиллаж, ЭМД-ын санхүүжилт нь байгууллагын нийт санхүүжилтын 74% -г эзэлж байгаа тул санхүүжилтээ авч үйл ажиллагаа явуулахын тулд урьдчилан сэргийлэх үзлэг ихээр хийгдэх болсноор лаборторын урвалж бодис, Гемодиализ, дурангийн аппаратын засвар үйлчилгээний хөлс, сэлбэг хэрэгсэл авахад төсөвлөгдөөгүй зардал их гарч байгаа учраас эмийн өр үүсэх гол шалтгаан болоод байна.</p> <p>БОЭТөвийн нийт хэвтэн эмчлүүлэгчийн тоо 2014 онд 11065 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн бол 2015 онд 12179 мянган хүн хэвтэн эмчлүүлж, 1114 мянган хүнээр илүү эмчлүүлсэн нь эмийн өрийг өсгөхөд нөлөөлсөн.</p> <p>Төрөөс үнэ төлбөргүй олгодог чихрийн шижин, бамбайн эм, хавдрын өвчлөл өссөнтэйгээр холбоотой эмийн зардал хэтэрсэн.</p> <p>Бөөрний диализид ордог өвчтөн урд оныхоос 5 хүнээр нэмэгдэж эмчилгээнд ордог болсонтой холбоотойгоор мөн Ховд аймгийн албан газар, сумын нийт албан газрын ажилчид урьдчилсан сэргийлэхийн үзлэгт хамрагддаг болсонтой холбоотойгоор эмийн өр бий болсон.</p> <p>2015 оны 08 дугаар сараас сүлжээ, интернетийн зардал 50 хувь танагдаж ирсэнтэй холбоотойгоор үүссэн</p> <p>2015 онд нийт санхүүжилтийн 74% -ийг Эрүүл мэндийн датгалаас авахаар төсөв батлагдаж ирсэн ба санхүүжилтийг бүрэн гүйцэт авч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахын тулд байгууллагын хэмжээнд жилийн турш 2 дахин их ачаалалтай ажилласан нь өр үүсэх үндсэн шалтгаан болсон.</p> <p>2016 онд төсвийн төсөөлөл хийхдээ эрүүл мэндийн даатгалын санхүүжилт нь нийт төсөвийн 42,7% байхаар хянуулсан ба батлагдаж ирсэн төсвийн 57%-г ЭМД-н санхүүжилт байгаа нь 2016 онд өрийн хэмжээ нь тодорхой хэмжээгээр буурна.</p>
11	Хэрэглэгчийн үнэлгээг ЭМСайдын 2014 оны 13 дугаар тушаалаар баталсан журмын дагуу зохион байгуулах	“Нийгмийн захиалга” ТББ –д хүсэлт тавьж хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн байна.	Байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн түвшин тодорхойлогдсоноор цаашид сайжруулах арга хэмжээг авч ажиллана.	<p>“Нийгмийн захиалга” ТББ –д хүсэлт захиалга өгч Орон нутаг дахь эрүүл мэндийн үйлчилгээнд өгөх хэрэглэгчийн үнэлгээг 1 удаа хийлгэсэн.</p> <ul style="list-style-type: none"> - БОЭТ-ийн эмч нарын хувийн ашиг сонирхолтой холбоотой асуудалд өгөх үнэлгээ 83,5%, - БОЭТ-ийн үйл ажиллагаанд иргэдийн өгч байгаа дундаж үнэлгээ 60,2%, - Ажилчдын зан харилцаа, үйлчилгээний орчны тав тухтай байдал- 40,7% - Эрүүл мэндийн үйлчилгээний тэгш байдал ашиг сонирхолын зөрчлийн талаарх хэрэглэгчдийн үнэлгээ 88,9% <p>Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Ховд аймгийн МХГ-ын хяналт үнэлгээг 2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Аймгийн МХГ-ын ХЭАХУБ Ш.Должинсүрэн ирж хийлгэхэд 32% буюу дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн.</p>

				Дээрхи 2 хөндлөнгийн үнэлгээгээр өгсөн зөвлөмжийн дагуу Ховд аймагт Эрүүл мэндийн салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойг угтан бүтээлч ажлуудыг зохион байгуулсан.
--	--	--	--	--

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХЯНАСАН

БОЭТ-ИЙН ЗАХИРАЛ

Т.БАЯРТОГТОХ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР

Ц.ЦАГААН

БАТЛАВ:

ХОВД ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН “ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ” ТӨЛӨВЛӨГӨӨ 2015 ОН

д\д	Хэрэгжүүлэх ажил	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах эзэн	Гүйцэтгэл
1.	БОЭТ-ийн албадуудын дарга болон тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарыг менежментийн сургалтанд хамруулах	Удирдлагын түвшинд чадавхжуулах сургалтыг холбогдох газраас сургагч багшийг урьж сургалт хийх	Удирдах ажилтнуудын менежмент \төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт үр дүнгээ тооцох \-ийн үйл ажиллагаа сайжирна.	2-дугаар улиралд	Сургалтын алба Б.Алтанчимэг	
2.	БОЭТ-ийн захирал албадын дарга болон тасгийн эрхлэгч нартай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж гэрээний биелэлтийг улирал тутам тооцож хяналт тавьж ажиллах	Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар баталсан журмын дагуу БОЭТ-ийн захирал бүх тасгийн эрхлэгч нартай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулсан байна.	Үр дүнгийн гэрээний биелэлтийг улирлаар дүгнэснээр ажлын хариуцлага хөдөлмөрийн бүтээмжид үнэлгээ өгч зохих арга хэмжээг авч ажиллана.	2015 оны 1 –р улиралд	Эмчилгээ эрхлэсэн дэд захирал Б.Анхбаяр, Хүний нөөцийн менежер Ц.Цагаан, сувилахуйн албаны дарга М.Бадамцэцэг, Чанарын алба Ч.Нямаахүү	
3.	Тусламж үйлчилгээний чанарын өдөрлөгийг амаржих газрын амбулаторийн тасаг, БОЭТ-ийн амбулаторийн тасгуудад хийж үр дүнг тооцох	Чанарын өдөрлөг хийх төлөвлөгөө боловсруулж төлөвлөгөөний дагуу зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан байна.	Чанарын хөтөлбөр боловсруулан төлөвлөгөөг гарган үр дүнг тооцсон байна.	жилдээ	Чанарын албаны багийн гишүүд	
4.	Хорт хавдрын бүртгэл, мэдээлэл, эргэн дуудах тогтолцоог боловсронгуй болгож, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах Хүний нөөцийг чадавхжуулах, Олон нийтэд хавдраас урьдчилан сэргийлэх үзлэг болон сургалт сурталчилгааг зохион байгуулах.	Аймгийн ЭМГ-ын дүн бүртгэлийн эмч, сум, өрхийн эмч, дүн бүртгэлийн бага эмч нартай уулзалт хийж оны эхэнд хорт хавдрын хяналтанд байгаа болон хөх, умайн хүзүү, элэгний скрининг үзлэгт хамрагдах зорилтот насны бүлгийн хүмүүсийн судалгаатай болно.	Хөх, умайн хүзүү, элэгний скрининг ийн үзлэгт хамрагдах зорилтот насны хүмүүсийн судалгааг гаргаж үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан байна. Олон нийтийн өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага сайжирна.	жилдээ	Эмчилгээ эрхлэсэн дэд захирал, Хавдрын кабинетийн эмч, хавдрын бүртгэл мэдээллийн ажилтан	

	БОЭТ-д үзүүлж байгаа зарим тусламж үйлчилгээний бодит зардлыг нэгдсэн аргачлалын дагуу тооцон дараа оны төсвийн төсөөлөлд тусгах	Бодит өртгийн тооцоо гаргасан тусламж үйлчилгээний төрөл, тоо	Байгууллагын төсвийн төлөвлөлтийг бодитойгоор тооцон эрх барих байгууллагад уламжлан шийдвэрлүүлсэнээр санхүүжилт нэмэгдэн тусламж үйлчилгээний чанар сайжирна	2-р улиралд	Эдийн засагч , Эмчилгээ эрхэлсэн дэд захирал, Ерөнхий нягтлан бодогч	
5.	НЭМ-ийн хөтөлбөр тус бүрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу тайланг хагас бүтэн жилээр гаргаж шалгуур үзүүлэлтэнд үнэлгээ өгөх, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хавтасжуулан баяжуулалт хийх НЭМ-ийн хөтөлбөр, стратегүүдийн хэрэгжилтийг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэхэд шинэ санаа, дэвшилтэт аргыг нэвтрүүлж , зарим хөтөлбөрийг орон нутгийн онцлогтой уялдуулан загвар хэлбэрээр хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах Зорилтот бүлгийн хүн амын \нөхөн үржихүйн насны, өсвөр үе, эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны \ эрэлт хэрэгцээнд тулгуурласан эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах. Осол гэмтэл, түлэгдэл, хордлогоос сэргийлэх сэрэмжлүүлэг, зөв зан үйлийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах Өглөөний алхалт, идэвхтэй хөдөлгөөн, зохистой хооллолт, эрүүл мэндийн хяналт зэрэг аянг зохион байгуулах	Хөтөлбөрүүдийн үзүүлэлтээр үнэлгээ гарна.	шалгуур Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана.	Хагас, бүтэн жилээр Сар бүр Улирал бүр	Эмчилгээ эрхэлсэн дэд захирал	
6.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бүс нутгийн хүн амд хүргэхэд чиглүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх, бүс нутгийн хүн амын эрэлт хэрэгцээ, нотолгоонд суурилсан үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх	1.Бүсийн харьяа аймгуудын алслагдсан сум багийн иргэдэд үндсэн нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгийг маршрутын дагуу зохион байгуулах 2.Бүс нутгийн хүн амын дунд эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйл,	Бүс нутгийн иргэдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	2,3-р улиралд жилдээ	Эмчилгээ эрхэлсэн дэд захирал Сургалт, эрдэм шинжилгээни	

		өвчлөл, нас баралтанд судалгаа хийж үр дүнг тооцох			й алба Б.Алтанчимэг	
7.	Харьяалах бүс нутгийн аймгуудын нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах, мэргэжил арга зүйгээр тогтмол хангах, эргэх холбоотой ажиллах	1.Харьяа аймгуудын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах санал хүргүүлж төлөвлөгөө боловсруулах 2. Бүсийн аймгуудын эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтнүүдийн дунд “Баруун бүсийн эрүүл мэндийн салбарын ололт, дэвшилтэт технологийн үр дүн” сэдэвт онол практикийн бага хурал зохион байгуулах 3.Харьяа аймгуудын нэгдсэн эмнэлгүүдэд шаардлагатай мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, эргэх холбоо тогтоон үр дүнг тооцож ажиллах 4.Бүс нутгийн эмнэлгүүдэд зарим мэргэжлийн эмч нарыг ажлын байрны солилцоо хэлбэрээр ажиллуулах, туршлага солилцох, 5. ХоИС, Политехник колжийн оюутнуудад үзүүлэх эрүүл тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Эмч мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар сайжирна. Бүсийн нутгийн оюутнуудад хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжрах		Эмчилгээ эрхэлсэн дэд захирал Сургалт, эрдэм шинжилгээг гадаад харилцааны алба Б.Алтанчимэг ЭЭО захирал Б. Анхбаяр Нийгмийн ажилтан О. Цагаанбилэг	
8	Эмнэлэгт хоног болоогүй нас баралт, даралт ихсэх өвчний болон зүрхний шигдээсийн нас баралтын тохиолдолд дүн шинжилгээг хийж бууруулах арга хэмжээ авч ажиллах	Тохиолдол бүрд судалгаа шинжилгээ болон эмгэг бүтцийн, клиник конференци хийгдсэн байна. Яаралтай тусламж болон амилуулах тусламжийн сургалтуудад хамруулна.	Нас баралтын түвшинг бууруулж, улс аймгийн дунджийн түвшинд хүргэнэ.	жилдээ	Эмчилгээ эрхэлсэн дэд захирал, чанарын алба	
9	Байгууллагын цахим хуудсын үйл ажиллагааг тогтмолжуулах,байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн, худалдан авалтын ил тод байдлыг ханган тодорхой ажлуудыг хийж ажиллана. Шилэн дансны хуулийн дагуу цэсийг байршуулж мэдээ мэдээлэлийг сар бүр шинэчлэх,мэдээллийн самбарыг олон нийтэд ил байршуулах	Байгууллагын Цахим хуудсан дээр бүх албад, тасгуудын цаг үеийн мэдээ мэдээлэл байнга тавигдсан байна. Сул чөлөөтэй ажлын байран дээр хүний нөөцийн сонгон шалгаруулалт зохион байгуулна.	Байгууллагын Цахим хуудасаар олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэгдсэн байна. Хүний нөөцийн ил тод байдал хангагдана. Тусламж үйлчилгээний чанар сайжирна.	жилдээ	Сүлжээний инженер Буянзаяа, Хүний нөөцийн менежер Ц.Цагаан	
10	Өр авлагүй ажиллах	Олон талт ажлуудыг зохион байгуулж ажиллана.	Өр авлага буурсан байна.	жилдээ	СТСЭрхэлсэн дэд захирал Я. Бямбадорж	

					Эдийн засагч Г.Саруулзаяа Ерөнхий ня-бо Д.Баярсүрэн	
11	Хэрэглэгчийн үнэлгээг ЭМСайдын 2014 оны 13 дугаар тушаалаар баталсан журмын дагуу зохион байгуулах	“Нийгмийн захиалга” ТББ –д хүсэлт тавьж хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн байна.	Байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн түвшин тодорхойлогдсоноор цаашид сайжруулах арга хэмжээг авч ажиллана.	2-р улиралд	Чанарын алба Ч.Нямаахүү	

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР

Ц.ЦАГААН